



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 509

Улаанбаатар хот

Хорооны 2011 оны 266 дугаар тогтоолоор
батлагдсан журамд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.3, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.10 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн 266 дугаар тогтоолоор батлагдсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.4.3 дахь заалтыг дараах байдлаар өөрчлөн нийruулсугай:

1/ 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 4.4.3 дахь заалт:

“4.4.3. банк бол Монголбанкны хяналт шалгалтаар хэвийн гэж дүгнэгдсэн байх”.

2. Мөн журмын 3 дугаар зүйлийн 3.12 дахь хэсгийн “3” гэснийг “5” гэж, “байна” гэснийг “байх” гэж тус тус өөрчилсүгэй.

3. Мөн журмын 3 дугаар зүйлийн 3.12 дахь хэсгийн “байх” гэсний дараа “бөгөөд хараат бус гишүүдийг Хорооны зөвшөөрлөөр томилно;” гэж нэмсүгэй.

4. Мөн журмын 4 дүгээр зүйлийн 8 дахь хэсгийн 4.8.4 дэх заалтыг хассугай.

5. Энэ журмын 3.12 дахь заалтыг 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

6. Журамд өөрчлөлтийг оруулж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН



000862